



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг Үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь "Монгол базальт" хувьцаат компани /цаашид "компани" гэх/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдэлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Компани нь ээлжит болон ээлжит бус аль ч хурлыг зарлан хуралдуулахдаа энэхүү журмыг баримтлан хурлын зарыг хүргэнэ.

### Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах

- 2.1 Компанийн төлөөлөн удирдах зөвлөл компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.
- 2.2 Компанийн ээлжит бус хурлыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч /цаашид "хурал зарлагч этгээд" гэх/ дараах тохиолдолд зарлан хуралдуулж болно. Үүнд:
  - 2.2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
  - 2.2.2 Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
  - 2.2.3 Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
  - 2.2.4 Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
  - 2.2.5 Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
  - 2.2.6 Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.
- 2.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрт хурал хуралдуулах газар, өдөр, цаг, хурлын хэлэлцэх асуудал, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт, саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр, хурлын дарга, хурал зохион байгуулах комисс, тооллогын комиссын дарга, гишүүдийг заавал тусгана.
- 2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 2.5 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд энэ өдөр нь энэхүү журмын 3.5-д заасны дагуу хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байхаар тогтооно.

- 2.6 Хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид “Хөрөнгийн бирж” гэх/-д хүргүүлнэ.
- 2.7 Энэхүү журмын 2.6-д заасан мэдэгдэлд дараах баримт, материалыг хавсаргасан байна.
- 2.7.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр;
- 2.7.2 Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд мэдээлэх зарын загвар;
- 2.7.3 Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хэлэлцэх асуудалд санал оруулсан бол түүний хуулбар;
- 2.7.4 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа.
- 2.7.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, саналын хуудасны хуулбар
- 2.8 Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно.
- 2.9 Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд, шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл уг шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.
- 2.10 Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт ажлын 3 хоногийн дотор дотор Хороо, Хөрөнгийн биржид хүргүүлнэ.

### **Гурав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх**

- 3.1 Хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, компанийн вэб сайт, өдөр тутмын 1 сонин, мөн радио, телевизийн аль нэгээр нийтэд мэдээлнэ.
- 3.2 Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө өдөр тутмын 1-ээс доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевиз дамжуулан хувьцаа эзэмшигчиддээ мэдээлнэ.
- 3.3 Энэ журмын 3.2-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлнэ.
- 3.4 Хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг энэ журмын 3.2-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.
- 3.5 Хурал зарлагч этгээд нь энэхүү журмын 2.5-т заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэдгийг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар нийтэд хүргэсэн өдрийг тооцно.
- 3.6 Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороонд ажлын 4 хоногт багтаан хүргүүлнэ.
- 3.7 Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас 10 болон түүнээс багагүй хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг энэ журмын 3.2-т заасан хэлбэр, шаардлагын дагуу дахин мэдээлнэ.
- 3.8 Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зар мэдээг нийтэд анх хүргэсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлнэ.



3.9 Компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хурлыг хуралдуулахаар төвлөсөн бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөрөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулна.

### **ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

- 4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.
- 4.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг хангахаар ТУЗ дараах асуудлуудыг тогтооно:
  - 4.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах хэлбэр (хувьцаа эзэмшигчдийг болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хуралд биечлэн оролцуулах замаар зохион байгуулна).
  - 4.2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, газар, цаг
  - 4.2.3 Хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр,
  - 4.2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал
  - 4.2.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээлэл, танилцаж болох баримт материалын жагсаалт
  - 4.2.6 Саналыг хуудсаар авах бол саналын хуудасны хэлбэр, агуулга,
  - 4.2.7 Хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөх эрх бүхий энгийн болон давуу эрхийн хувьцааны ангилал
  - 4.2.8 Хурал удирдах дарга, хурлыг зохион байгуулах бүрэлдэхүүн
  - 4.2.9 Тооллогын комиссын дарга болон гишүүд
- 4.3 Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд бэлтгэх ба ТУЗ-ын төвлөсөн бүртгэлийн өдрөөр тасалбар болгон жагсаалтыг гаргуулан авч, хурлыг тооллогын комисст хүлээлгэн өгнө.
- 4.4 Бүртгэлийн өдрийг ТУЗ тогтоох ба хурал зарлагч этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу тогтооно.
- 4.5 Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг компанийн байранд төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга компанийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшигчид этгээдийн хүсэлтийн дагуу танилцуулна.
- 4.6 Хэрэв хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцаагаа хурлаас өмнө зарсан, шилжүүлсэн, өвлүүлсэн, бэлэглэсэн бол:
  - 4.6.1 Шинэ хувьцаа эзэмшигчид итгэмжлэл гаргаж өгнө.
  - 4.6.2 Шинэ хувьцаа эзэмшигч зааврын дагуу ХЭХ-д санал өгнө.
- 4.7 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч нь бүртгэлийн өдрийн дараа шилжүүлсэн хувьцааныхаа хувьд итгэмжлэл гаргасан бол тухайн хувьцааг шинээр

ЭЗЭМШИГЧ ИХ ХУВЬЦААГАА ТУХАЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССТ БҮРТГҮҮЛЖ, САНАЛЫН ХУУДАС АВАХ БА ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХТЭЙ.

4.8 Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах үед ямар нэг алдааны улмаас хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад ороогүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос өмнө хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад өөрчлөлт оруулж болно.

4.9 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг СЗХ-оос тогтоосон журмын дагуу зохицуулна.

4.10 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэсэн өдрөөс болон хувьцаа эзэмшигчдийн бэлтгэлийн явцад ХЭХ-д оролцох эрх бүхий этгээдэд хүргүүлэх мэдээлэл болон материалд дараах зүйлүүд орно:

4.10.1 Жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудиторыг тайлангийн хамт

4.10.2 ТУЗ –ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн тухай мэдээлэл, тэдгээр нэр дэвшигчдэд олгох цалин/урамшууллын тухай мэдээлэл,

4.10.3 Тайлангийн хугацаанд компаниас байгуулсан сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний байгаа бол тэдгээр хэлцлүүдийн талаарх мэдээлэл, аудиторын дүгнэлт мэдээлэл

4.10.4 Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт эсвэл шинэчилсэн найруулгын төсөл

4.10.5 Компанийн нэгдмэл сонирхол бүхий этгээдүүдийн нэрсийн жагсаалт, тэдний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл,

4.10.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл болон бусад холбогдох материал.

4.11 Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комисс тухайн хуралд оролцох эрх бүхий этгээд холбогдох мэдээлэл, материалтай танилцах боломжоор хангах ба хурлыг зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс 5 хоногийн дотор үнэт цаасны компаниуд мэдээллийг хүргүүлсэн байна.

4.12 Хэлэлцэх асуудлаар санал хураалтыг саналын хуудсаар явуулна.

4.13 Саналын хуудас хүлээн авах сүүлийн өдрийн ТУЗ тогтооно.

4.14 Саналын хуудсанд дараах мэдээлэл орно:

4.14.1 Компанийн оноосон нэр болон хурал болох газрын байршил:

4.14.2 ХЭХ хуралдах өдөр, газар, цаг болон бөглөсөн саналын хуудсыг эргүүлэн хүргүүлэх шуудангийн хаяг:

4.14.3 Саналын хуудсаар санал өгөх шийдвэрлэх асуудал бүрийн томъёолол (эсвэл нэр дэвшигч бүрийн нэр):

4.14.4 Хэлэлцэх асуудал бүрээр санал өгөх (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”):

4.14.5 Хэрэв кумулятив аргаар санал хураах бол кумулятив аргыг тайлбарласан холбогдох тэмдэглэл, тайлбар:



4.14.6 Компанийн ТУЗ-ын гишүүдийг сонгоход кумулятив аргаар санал хураах бол тухайн саналын хуудсанд нэр дэвшигч бүрийн нэрийн ар талд зай үлдээсэн байх (нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог энд бичнэ)

4.14.7 Саналын хуудсанд хувьцаа эзэмшигч заавал гарын үсэг зурна гэсэн тэмдэглэл байх,

4.15 Хэрэв саналыг хувьцаа эзэмшигчийн төлөөлөгч өгч байгаа бол бөглөсөн саналын хуудсыг хувьцаа эзэмшигчийг төлөөлөх эрхийн итгэмжлэлийн хамт компанид хүргүүлнэ.

4.16 Хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон болон эдгээр хүмүүсийн эрхийг итгэмжлэлээр эсвэл Хуулийн дагуу төлөөлөх хүмүүс оролцох эрхтэй.

4.17 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий этгээдийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр бүртгэнэ. Бүртгэл ХЭХ эхлэхээс өмнө 1 цагаас доошгүй хугацаанд эхэлнэ. Саналын хуудсаар хуралд оролцогчдыг тооллогын комисс бүртгэлийг хурал эхлэхээс 1 цагийн өмнө бүртгэлийг хийж дуусгана.

4.18 Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцогсдын бүртгэлийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах байранд тооллогын комисс хийнэ.

4.19 Зөвхөн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүс иргэний үнэмлэхээ үзүүлэн ХЭХ-д оролцохоор бүртгүүлж болно.

4.20 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хүмүүсийг иргэний үнэмлэхийг нь хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт дахь өгөгдлүүдтэй тулган үзэж бүртгэнэ.

4.21 Тооллогын комиссын ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

4.22 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохоор бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчид (эсвэл тэдний төлөөлөл) болон компани саналын хуудсыг нь хүлээн авсан хувьцаа эзэмшигчдийг (тэдний төлөөлөл) хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.

4.23 Дараах хүмүүс ХЭХ-д оролцоно:

4.23.1 Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон этгээд болон тэдний эрх бүхий төлөөлөл

4.23.2 Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, гүйцэтгэх захирлууд, хөндлөнгийн аудитор

4.23.3 ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нар

4.23.4 Тооллогын комиссын дарга, гишүүд,

4.23.5 ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын урьсан хүмүүс.

4.24 Хувьцаа эзэмшигч нь өөрийн төлөөллийг солих эсвэл өөрөө ХЭХ-д биечлэн оролцох эрхтэй бөгөөд төлөөллийг солих бол тооллогын комисс буюу компанид ХЭХ эхлэхээс өмнө бичгээр мэдэгдэнэ.

4.25 Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

4.26 Хэлэлцэх бүх асуудлаар ХЭХ-ыг эхлэх үед ирц (кворум) бүрэлдээгүй бол ХЭХ-ыг нээн хуралдуулах хугацааг 19 өдрөөр хойшлуулна.

4.27 ХЭХ-ын хэлэлцэх асуудалд хувьцаа эзэмшигчдийн янз бүррийн бүлгүүд (энгийн, давуу эрхийн хувьцаа эзэмшигч) санал өгөх байвал тухайн хэлэлцэх асуудал бүрт ногдох ирц квормыг тухайн асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө тооллогын комисс тогтооно.

- 4.28 Ирц бүрдээгүйгээс ХЭХ-ын товыг дахин товлох тохиолдолд хэлэлцэх асуудалд өөрчлөлт орохгүй.
- 4.29 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрийг дахин товлох шийдвэрийг ХЭХ-ийг анх хуралдуулах шийдвэр гаргасан этгээд гаргана.
- 4.30 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг компанийн байранд эсвэл дийлэнх хувьцаа эзэмшигчдийн хувьд очиход төвөггүй өөр газар хуралдуулж болно.
- 4.31 Хувьцаа эзэмшигчдийн хурал нэг өдөрт багтахгүй бол ХЭХ-ын дарга дараа өдрийн өглөө хүртэл хурлыг завсарлуулж болно.
- 4.32 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга нь ХЭХ-д хэлэлцэх асуудлын дагуу тавигдах илтгэлүүдийн дарааллыг тогтоох ба ХЭХ-ын тэмдэглэлд \проткол\ гарын үсэг зурна.
- 4.33 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга нь ТУЗ-ын дарга байх бөгөөд түүний эзгүйд ТУЗ-аас томилсон ТУЗ-ын аль нэг гишүүн даргална.
- 4.34 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахыг ТУЗ татгалзсан тохиолдолд, ХЭЭБХ-ыг хуралдуулахаар зарласан этгээд ХЭЭБХ-ын даргыг томилох эрхтэй.
- 4.35 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг хурал зарлагч этгээд тогтоох бөгөөд ХЭХ-ын эхэнд, Тооллогын комиссын дарга ХЭХ-ын ирцийг мэдээлж, ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар тайлбарлана.
- 4.36 ХЭХ-ын дарга хувьцаа эзэмшигчдэд одоогийн ТУЗ болон ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигчид Компанийн тухай хуулийн заалтын дагуу хараат бус байх шалгуурыг хангаж байгаа эсэх талаар мэдээлэл хийнэ.
- 4.37 ХЭХ-ын бүх оролцогсад санал хураах хэлэлцэх асуудлаар санал бодлоо илэрхийлэх, асуулт хариултын 2 минут өгнө.
- 4.38 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга нь хэлэлцэх асуудлаар явагдах хэлэлцүүлгийн Үр дүнтэй байх нөхцөлийг хангаж, санал хураахгүй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхгүй байна.
- 4.39 Хэлэлцэх асуудлын сүүлийн асуудлыг хэлэлцэж дууссаны дараа, хувьцаа эзэмшигчдийн санал хураалтыг явуулах ба тооллогын комисс саналын хуудсыг хүлээн авч, хэлэлцэж буй асуудлаар саналыг тоолж, саналын дүнг нэгтгэн гаргаж, хурлын дүнг мэдээлнэ. ХЭХ-ын дарга гарсан шийдвэрийг танилцуулж хурлыг хаана.
- 4.40 ХЭХ дээр санал өгөхдөө нэг хувьцаа нэг санал гэсэн зарчмыг баримтлах ба харин кумулятив аргаар санал хураахад энэ зарчим хамаарахгүй.
- 4.41 Санал авах хуудсанд ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр нэг санал өгөх хувилбараар тэмдэглэл хийгдэнэ. Энэ журмыг зөрчиж тэмдэглэл хийгдсэн саналын хуудас тухайн буруу тэмдэглэл хийгдсэн асуудлын хувьд хүчингүйд тооцно.
- 4.42 Нэг эсвэл хэд хэдэн асуудлаар буруу тэмдэглэл хийгдсэн саналын хуудас нь бүхэлдээ хүчингүйд тооцогдохгүй.



## **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ЯВУУЛАХ**

- 5.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг хурлыг хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалтаар гаргаж болно.
- 5.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон дахин товлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр явуулахыг хориглоно.

### **ЗУРГАА. ШИЙДВЭР ГАРГАЛТ БА БАРИМТ БИЧГИЙН ХӨТЛӨЛТ**

- 6.1 Дараах асуудлаар шийдвэрийг ХЭХ-д оролцогсдын 3/4-дийлэнх олонхын саналаар гаргана.
- 6.1.1 Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах
- 6.1.2 Компанийг өөрчлөн байгуулах
- 6.1.3 Компанийг татан буулгах ба татан буулгах комиссыг томилох
- 6.1.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх
- 6.1.5 Нэмэлт хувьцаа гаргах, гаргах хувьцааны тоог тогтоох, компанийн өрийг хувьцаагаар солих,
- 6.1.6 Компанийн хувьцааг хуваах болон нэгтгэх.
- 6.2 Давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарлахтай холбогдсон нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах эсвэл компанийн шинэ дүрэмд баримталж эхлэхтэй холбогдсон шийдвэрт дараах байдлаар санал өгсөн бол шийдвэр гарсанд тооцно.
- 6.2.1 ХЭХ-д саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (3/4-аас цөөнгүй хувь нь оролцож санал өгсөн байх ба үүнд эрхээ хязгаарлуулж байгаа давуу эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн саналыг оролцуулахгүй),
- 6.2.2 Эрх нь хязгаарлагдах гэж байгаа давуу эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.
- 6.3 Бусад бүх асуудлаар ХЭХ-д оролцогч саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэр гаргана.
- 6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тэмдэглэл болон санал хураалтын дүнгийн тухай тайланг ХЭХ-ын дараа бэлтгэн гаргана. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг ажлын 3 хоногийн дотор бэлэн болгох ба хурлын протолыг хурлаас хойш 15 ажлын өдрийн дотор бэлэн болгоно.
- 6.5 Тооллогын комисс нь санал хураалтын дүн болон дүнгийн тэмдэглэлийг ХЭХ дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор бэлэн болгоно. Санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын тэмдэглэлд тооллогын комиссын дарга болон гишүүд гарын үсэг зурна.
- 6.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурал дууссанаас хойш 15 өдрийн дотор хоёр хувь үйлдэнэ. Хоёр хувь дээр хурлын дарга гарын үсэг зурна. Тооллогын комиссын бэлтгэсэн санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэлийг ХЭХ-ын тэмдэглэлд хавсаргана.
- 6.7 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

- Компанийн хууль ёсны нэр ба хаяг,
- 6.7.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын төрөл (ХЭЭХ эсвэл ХЭЭБХ),
- 6.7.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлбэр,
- 6.7.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо болон хугацаа,
- 6.7.5 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан газар,
- 6.7.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцсэн асуудал,
- 6.7.7 Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүсийн саналын тоо нь хэлэлцэх асуудал бүрт
- 6.7.8 Ирц бүрдсэн нөхцөлд өгсөн санал бүр нь тухайн асуудлын хувьд (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”) хүчин төгөлдөр байна.
- 6.7.9 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол,
- 6.7.10 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, хурлын тэмдэглэл хөтөлсөн этгээдийн нэрс,
- 6.7.11 ХЭХ-ын тэмдэглэл (протокол) үйлдсэн огноо,
- 6.7.12 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр.
- 6.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд бичсэн ХЭХ-ын асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол нь саналын хуудсанд бичигдсэн тухайн шийдвэрийн томъёоллоос өөр байж үл болно.
- 6.9 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурагдсаны дараа, тооллогын комисс саналын хуудсуудыг лацдаж, компанийн архивт хадгална.
- 6.10 Тооллогын комиссын ХЭХ-ын санал хураалтын дүнгийн тухай тайлан тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:
- 6.10.1 Компанийн оноосон бүтэн нэр, хаяг,
- 6.10.2 ХЭХ-ын төрөл \ХЭЭХ эсвэл ХЭЭБХ\ болон хуралдуулсан хэлбэр,
- 6.10.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцсэн асуудал,
- 6.10.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудлууд, тухайн асуудлуудаар товлосон хугацаанд саналын хуудсаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсний жагсаалт болон тэдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо,
- 6.10.5 Хэлэлцсэн асуудал бүрээр хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн этгээдүүдээс хуралд биечлэн болон төлөөлөн оролцсон этгээдээс саналын хуудсаа ирүүлэгүй бол тэдгээрийн саналын тоо,
- 6.10.6 Хэлэлцсэн асуудлаар ирц бүрдсэн эсэх тухай мэдээлэл,
- 6.10.7 Ирц бүрдсэн нөхцөлд хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын тоо (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”),



Эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын хүчингүй болсон хуудасны тоо,

Хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол,

Тооллогын комиссын үүргийг гүйцэтгэсэн хөндлөнгийн байгууллагын нэр, хаяг, тухайн байгууллагаас ХЭХ-ын Тооллогын комиссын ажлыг эрхлэн гүйцэтгэх эрх олгосон хүмүүсийн нэрс,

6.10.11 Тооллогын комиссын дарга болон гишүүдийн гарын үсэг,

6.10.12 Санал хураалтын дүнгийн тайланг бичсэн огноо,

6.11 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд нэгдмэл сонирхолтой талуудын хэлцэлтэй холбогдсон асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэл, санал хураалтын дүнгийн тухай тайланд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.

6.11.1 Хувьцаа эзэмшигчдийн нэрсний жагсаалтад орсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хүмүүсийн саналын тоо,

6.11.2 ХЭХ-д биечлэн оролцсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хүмүүсийн саналын тоо,

6.11.3 Асуудал бүрээр өгсөн саналын тоо (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”)

6.12 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан тогтоол шийдвэрийг компанийн цахим хуудас болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлж болно.

## **ДОЛОО. БУСАД**

7.1 Энэхүү журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн Зохицуулах Хороон болон Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан журамд зааснаар шийдвэрлэнэ.